



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 8 сарын 18 өдөр

Дугаар 297

Улаанбаатар хот

Бүртгэлд хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх журам"-ын 4.4 дэх заалт, улсын байцаагчийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.6 дахь заалтыг зөрчсөн "Ай эм тек" ХХК-ийг тухайн зөрчлийг гаргаснаас хойш 3 жилийн хугацаагаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсугай.

Хоёр. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн газар, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Ганбат/-т даалгасугай.

Гурав. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн эрх захирагч-захиалагч нарт зөвлөсүгэй.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

000705

Сангийн сайдын 21 дугаар сарын 18-ны
өдрийн 27 дугаар тушаалын хавсралт

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд
хамруулах этгээдийн нэрс

№	Гүйцэтгэгч компанийн нэр	Гаргасан зөрчил	Зөрчил гаргасан огноо	Бүртгэлд хамруулах хугацаа дуусгавар болох огноо
1.	"Ай Эм Тек" ХХК	Үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэн	2016-05-11	2019-05-11